

Их дээд сургуулийн багш, оюутны харилцааны талаарх судалгаа

Ж.Тунгалаг*, Ц.Ганцэцэг
МУИС-ийн Бизнесийн сургууль

Хураангуй

Энэ судалгаанд багш, сурагчдын харилцааны өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээлүүдийн талаархи одоогийн нөхцөл байдлыг тодорхойлохыг зорьж байна. Судлаачид сурагчдын хоорондын харилцаа холбоо, багшийн заах ур чадвар, бие даасан байхын ач холбогдлын зэрэгцээ багшийн чанарыг үнэлэх асуудлын талаар өөрийн дүгнэлттэй байдаг. Цахим орчинд амьдарч буй орчин үеийн оюутнууд өмнөх үеийнхээс олон янзын нөхцөл байдалд амьдарч, үнэлэлт дүгнэлт өгч чаддаг болсон ч багш нарыг хүндэтгэх соёлын чухал уламжлал алдагдаж, багш нарыг ялгаварлан гадуурхаж буй багш нар гэр бүл, нийгмийн нөлөөллөөр мөнгөөр ямар нэг юм хийдэг. Энэ нь багш нарын зарим хөгжлийг тасралтгүй сайжруулж, цаг хугацаа шаардсанаар оюутны хөгжилд мэдлэг, туршлагаа сайжруулж байх явдал юм.

Өнөөгийн багш-оюутны харилцааг оюутнуудын 40 хувь нь сайн, 56 хувь нь дунд зэрэг хэмээн үнэлж байгаагаас үзвэл багшийн зүгээс оюутантай харилцах ажиллагаанд дутагдалтай тал багагүй байна. Багш-оюутны харилцаанаас шалтгаалж оюутнууд өөрт тулгарсан бэрхшээлийг тэр бүр ярьдаггүй бөгөөд учир нь багшаас эмээдэг, ярьж чадсан ч сайн үр дүн гарахгүй гэж боддог ажээ. Багш-оюутны харилцааны талаар хийсэн судалгаанаас нэгтгэн дүгнэхэд багш нарын харилцаа, оюутанд хандах хандлага, сурган хүмүүжүүлэх арга барилыг сайжруулах өөрчлөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Түлхүүр үг

Боловсрол, сурган хүмүүжүүлэгч, үнэлгээ, МУИС, ШУТИС, ОУУБИС

Удиртгал

2018 оны байдлаар Монгол Улсад нийт 85 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байна. Оюутан залуус маань оюутан ахуй үедээ жинхэнэ хүн болон төлөвшиж гүйцэх, улмаар эзэмшсэн мэргэжлээрээ гадаад, дотоодод ажиллах чадвартай болох зайлшгүй шаардлагатай. Ийм чадвартай болохын тулд их, дээд сургуулийн сургалтын чанарыг улам дээшлүүлэх явдал чухал бөгөөд үүнд нөлөөлж буй нэгэн хүчин зүйл нь багш оюутны харилцааны асуудал болж байна.


Багш-оюутны харилцааны асуудал зөвхөн оюутанд төдийгүй багш нарын анхаарвал зохих чухал сэдэв бөгөөд нэр хүндтэй, чадварлаг багш байж, оюутанд үлгэр дуурайл үзүүлэх нь чухал билээ. Орчин үед боловсролын аль ч түвшний багшийн нэр хүнд өмнөх үеийг бодвол буурсан нь амьдралаас харагддаг бөгөөд энэ нь анхаарахгүй байхын аргагүй асуудлын нэг мөн. Энэхүү судалгааг төрийн болон хувийн хэвшлийн 4 сургуулийн оюутнууд хамрагдсан бөгөөд багш-оюутны харилцаанд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, шалтгааныг тодорхойлон дүгнэлт

өгөхөд судалгааны үндсэн зорилго оршиж байна.

Судалгааг анхдагч мэдээлэл цуглуулах асуулгын аргаар авч, эконометрикийн аргаар SPSS 20 программ дээр боловсруулсан. Бидний судалгаанд МУИС, ХААИС, ОУУБИС, ШУТИС-ийн нийт 337 оюутан хамрагдсан бөгөөд түүвэр судалгааг 12 асуулт бүхий асуулгын хуудсаар 2018 оны 4, 5 дугаар сард авав. Судалгаанд нэр бүхий сургуулийн оюутнууд дараах байдлаар оролцсон байна. МУИС-ийн 159 оюутан (47%) хамрагдсанаас 75 шахам хувийг МУИС-ийн Бизнесийн сургууль, үлдэх хувийг бусад бүрэлдэхүүн сургуулийн оюутнууд эзэлж байна. ОУУБИС-ийн 100 оюутан (30%), ШУТИС-ийн 45 (13%), ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн 33 (13%) оюутан тус тус хамрагдсан. Үүнээс үзэхэд сургуулиудаас харилцан адилгүй судалгаанд оролцсон байна. Гэвч багш-оюутны харилцааг өнөө цагийн оюутнууд хэрхэн үзэж байгаа талаарх судалгаанд төдийлөн нөлөөлөхгүй гэж үзэв.

* ✉ tuna7881@yahoo.com

График1
Судалгаанд оролцогчдын хувь



Нэг. Багшийн ёс суртахуун

Багшийн үйл ажиллагаа нь хувь хүний төлөвшил, хөгжил, ёс суртахуун, ёс зүйтэй нь салшгүй холбоотой юм.

“Ёс суртахуун нь хүмүүсийн хоорондын харилцаа, энэ харилцаанаас үүдэн гарах үүргийн тухай шинжлэх ухаан юм” гэж Францын философич П.Гольбах¹ тодорхойлсон байна. Ёс зүй (этика) бол нийгмийн шинжлэх ухаан бөгөөд сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, гоо зүй, нийгэм судлалтай холбоотой юм. Зарим багшийн хувьд ёс суртахуун болон ёс зүйн мэдлэг дутагдалтай байгаагаас харилцааны соёл хангалтгүй явдал байдаг.

“Багшийн ёс суртахуун” өгүүлэлдээ багшийн шударга чанар, сурган хүмүүжүүлэх ая дангийн талаар бичжээ. Шударга чанар бол багшийн ёс суртахууны соёл ямар түвшинд байгааг харуулдаг байна. “Сурган хүмүүжүүлэх ая дан гэдэг нь хүний төлөө анхаарал халамж тавих, өрөвч зөөлөн сэтгэлээр хандах, хүмүүсийн хооронд гарсан зөрчлийг сайн сайхныг хүсэж төгсөх хүртэл харилцаанд аваачих хэрэглүүр” хэмээн өгүүлсэн нь багш нар анхаарах нь чухал юм. Тэрбээр “Ая дантай байх гэдэг нь дутагдалд эвлэршгүй зарчмаар хандахын хамт нөхөрсөг харилцаагаа хадгалахад оршино. Энэ нь багшийн дотоод соёл, ёс суртахууны ухамсартай холбоотой” гэжээ. (Дүнчээ, 2008, х5)

Ёс суртахуунгүй багш мэдлэг, чадвар, дадлага туршлагатай байлаа ч шавь нарын итгэл хүндэтгэлийг хүлээж чаддаггүй байна. Ёс суртахууны соёлд цав суулгадаг нэг үйлдэл нь багшийн үг яриа юм. Үг яриа нь багш нарын харилцааны хамгийн чухал зэвсэг хэрэглүүр мөн.

Сурган хүмүүжүүлэх ая данд дараах үйлдлүүд ордог байна. Үүнд:

- Эрээ цээр гаргалгүй энгийн байдлаар хандах
- Чин сэтгэлээсээ, мэдрэмжтэй, намуухан ярьж, тайлбарлах
 - Шавьдаа итгэхдээ дур зоргоор нь тавихгүй байх
 - Үглэж залхаалгүйгээр удирдамж зөвлөгөө өгөх
 - Санал асуулга, санамж анхааруулгын хэлбэрээр нөлөө үзүүлэх
 - Шавийн бие даасан байдлыг дарж сөргөхгүйгээр итгүүлж, шаардах
 - Шоолж шоглохгүйгээр егөөдөж алиалах
 - Зулгуйдаж долигонолгүй сайн сайхныг хүсэж ерөөх
 - Зөрүүдэлж гөжүүдлэлгүй шаргуу зан гаргах
 - Ажил хэргийн харилцаанд цухалдалгүй, бодолтой, өөрийн гэсэн өнгө төрхтэй хандах
 - Шийдвэрийг яарч сандралгүй, хуумгайралгүй гаргах, хүлээн авах
 - Ёс журам номлолгүйгээр ярилцах.

Хоёр. Багш оюутны харилцааны түвшин

УБИС-ийн багш Д.Баярмаа багш оюутны хамтын үйл ажиллагааг үндсэн гурван түвшинд явагддаг гэж үзжээ. Үүнд:

- Дээгүүр - харилцаа хандлага нь халуун дотно, бие биеэ сайн ойлгодог, харилцан гүн итгэдэг (өөдрөг хандлагатай)
- Дунд зэрэг-төдийлэн дотно биш, бие биеэс зай барьсан, тухайн үеийн нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг (тодорхойгүй хандлагатай)
- Доогуур - хөндий хүйтэн, үл ойлголцдог, харилцан туслалцаж чаддаггүй (гутранги хандлагатай)

Харилцааны түвшин нь багшийн оюутанд нөлөөлөх чадвартай шууд холбоотой байдаг ажээ. Судлаач Б.Г.Ананьев² энэхүү нөлөөллийг эерэг (*бие даах чадварыг нь сайшаах, зөвшөөрөх, сагтах, хүсэх, гуйх, зөвлөх, саналаа хэлэх*) болон сөрөг (*зэмлэх, шоолох, гомдоох, заналхийлэх, айлгах*) гэсэн хоёр хэлбэртэй гэж үзсэн байна.

Харилцаа хандлагын хэв маяг нь хичээл дээр багш суралцагчтай хамтын ажиллагаа явуулах үйл явцад зан төлөвийн хэд хэдэн загварыг бий болгодог бөгөөд эдгээрийг дараах хэлбэрт ангилж болно.

1 P.Holbach (1723-1789)

2 B.G.Ananyev

Хүснэгт 1

Харилцаа хандлагын хэв маяг

№	Зан төлөвийн загвар	Сургалтын хэлбэр	Үр дагавар
1	Дарангуйлах загвар (“монблан”)	Багш оюутанд хөндий хүйтэн ханддаг. Багш мэдлэгээрээ суралцагчдыг төөнөж, зөвхөн мэдээлэл өгөх бөгөөд оюутнууд зөвхөн идэвхгүй сонсогчид болдог. Тэдний хооронд ямар ч холбоо харилцаа үүсдэггүй.	Сэтгэл зүйн холбоо харилцаа тогтоогүй тул оюутан идэвх санаачилгагүй байдалд орно.
2	Харилцаа холбоо үл тогтоох загвар (“цагаан хэрэм”)	Дарангуйлах загвараас ялгаатай нь багш оюутны хооронд гэнэтийн санамсаргүй болон зориудын саад бэрхшээл үүсдэг боловч тэдний хооронд ямар нэг хэмжээгээр буцах холбоо бий болно. Багш оюутны аль нэг нь нөгөөтэйгээ хамтран ажиллах хүсэл сонирхолгүй байх, хичээл нь хэлэлцүүлгийн бус зөвхөн мэдээлэл өгөх төдий шинж чанартай болох, багш өөрийн байр сууриа хяналт болгоомжгүй, дөвийлгөн хэлэх, оюутанд өршөөнгүй, хүлцэнгүй хандах байдалтай.	Багш оюутны хоорондын харилцаа идэвхгүй сул, оюутны багшид хандах байдал төдийлөн сайнгүй.
3	Хувийн сэтгэл зүйн онцлогийг харгалзан үзэж хандах загвар (“локатор”)	Багш оюутанд хандахдаа шилж сонгодог. Тэрбээр ангийн бүх оюутнаар баримжаа авалгүй зөвхөн зарим нэгд нь тухайлбал арай илүү авьяас билигтэй, манлайлагч, эсвэл сул, идэвхгүй оюутныг илүү анхаарах үздэг. Харилцааны явцад багш тэдэн дээр тулгуурлаж анги хамт олны санаа сэтгэлд нөлөөлөхийг урьтал болгоно.	Багш оюутны хамт олны харилцаанд нэгдмэл үйл ажиллагаа алдагддаг. Хүмүүсийн хоорондын харилцаа тухайн үеийн нөхцөлөөс шалтгаалах буюу өнгөц байдалд явагддаг.
4	Хаалттай, хязгаарлагдмал загвар (“эр хур”)	Багшийн үг яриа дотогш чиглэсэн байна. Тэрбээр амандаа бувтнаж, зөвхөн өөрийгөө сонсдог. Суралцагчдын хүсэл сэтгэлийг тэр бүр татаж чаддаггүй, харилцаж буй хүний тавьж буй асуултыг анхаардаггүй. Иймэрхүү багш хамтын үйл ажиллагаанд зөвхөн өөрийн бодол санаанд автагддаг сэтгэлийн хөдөлгөөнөө ил гаргадаггүй.	Багш оюутны хооронд харилцаа холбоо бараг байдаггүй. Багш өөрийгөө тойруулан сэтгэл зүйн хоосон зай бий болгодог. Харилцагч талууд нэг нь нөгөөгөөс хол хөндий байдаг, сурган хүмүүжүүлэх нөлөөлөл өс төдий явагддаг.
5	Нээлттэй загвар (“чанга дуу хоолой”)	Сэтгэл зүйн хувьд дээр дурдсан хаалттай, хязгаарлагдмал загварын эсрэг загвар юм. Багш харилцааны агуулгад сэтгэл гаргахаас гадна бусад хэрхэн хүртэгдэн тусгагдаж буйгаа анхаарна. Ийм багшийн хувьд харилцаж буй хүмүүсийн нь хандлага чухал байр суурьтай байна. Алив харилцаа хандлага яг түүний санаснаар байх ёстой гэж үздэг. Тэрбээр өөрийн үзэл бодол, үйл хөдлөлийн зөв эсэхэд үргэлж эргэлздэг. Оюутны сэтгэл зүйн уур амьсгалын ямар нэгэн өөрчлөлт хувирлыг соргог мэдэрч өөрийнхөөрөө авч үздэг.	Суралцагчдын үг яриа, үйл хөдлөлд таарч тохироогүй хариу өгөхөд хүргэдэг, нийгэм-сэтгэл зүйн хурц мэдрэмжтэй багш юм.
6	Уян хатан бус загвар (“робот”)	Хичээлийн зорилго, зорилтыг ягштал биелүүлэхийн тулд багш оюутны харилцаа хандлага хатуу чанга тогтсон хөтөлбөрөөр явагддаг. Багш өөртөө зөв гэж үзсэн сургалтын арга барилыг л хэрэглэдэг. Багш өөрчлөгдөн хувирч буй орчин нөхцөлийг ойлгож мэдрэх чадвар сул, сурган хүмүүжүүлэх үйл явц, оюутны сэтгэцийн үзэгдэл, нас, ёс заншлыг харгалзан үздэггүй. Бодож боловсруулж, сайтар бэлтгэсэн хичээл нь нийгэм-сэтгэл зүйн хувьд бодит байдалд хэрэгжихгүй, улмаар зорилгодоо хүрдэггүй.	Сурган хүмүүжүүлэх харилцан үйлчлэлийн үр нөлөө бага.
7	Захиран тушаах загвар (“би өөрөө”)	Сурган хүмүүжүүлэх үйл явцын ид шидтэн. Тэрбээр цорын ганц гол хүн, асуулт тавьж өөрөө хариулдаг. Гол санааг гаргаж, түүнийгээ өөрөө баталдаг. Багш оюутны хооронд бүтээлч уялдаа холбоо ерөнхийдөө үүсдэггүй. Багшийн нэг талын үйл хөдөлгөөн нь оюутан суралцагчдын идэвх санаачилгыг бууруулдаг учир тэд өөрсдийгөө гүйцэтгэгчийн байр сууринд авчирч зөвхөн багшийн зүгээс ирэх заавар зөвлөгөөг хүлээж суудаг. Оюутны танин мэдэхүйн болон нийгмийн идэвх доод цэгтээ хүрдэг.	Суралцагчид идэвх санаачилгагүй болж, сургалтын бүтээлч шинж чанар алдагддаг. Үзэгдэл юмсыг танин мэдэх гэсэн хүсэл тэмүүлэл мохдог.
8	Идэвхтэй харилцах загвар (“холбоо тогтоогч”)	Багш суралцагчидтай байнга харилцан ярилцдаг. Тэдний сэтгэл санааг эерэг түвшинд барьж чаддаг. Идэвх санаачилгыг нь сайшаан магтаж, урам хайрлааг, бүлгийн сэтгэл зүйн уур амьсгалд гарч буй өөрчлөлтийг амархан мэдэрч, түүнд уян хатан хандаж чаддаг.	Үүсэж буй сургалт, хүмүүжил, зохион байгуулалт, ёс зүйн асуудлыг хамтын хүчээр бүтээлч байр сууринаас шийдвэрлэдэг. Энэ нь нэлээд үр дүнтэй загвар юм.

Гурав. Багш болон багш-оюутны хоорондын харилцааны талаарх оюутнуудын үзэл бодлын судалгаа

Бидний хийсэн судалгааны хамгийн эхний асуулт нь оюутнуудын хувьд багш гэж хэн бэ гэсэн асуулгаар эхэлсэн юм. Судалгаанд оролцогчдын 40 гаруй хувь нь багшийг “сурган хүмүүжүүлэгч”, бараг тал хувь нь “мэдлэг өгөгч” хэмээн үздэгээс харахад багшийг үндсэндээ шавь нарыг сурган боловсруулдаг, шинжлэх ухааны мэдлэгийг түгээгч хэмээн үздэг нь харагдаж байна. Багш хүний хамгийн их анхаарах зүйл нь мэдлэгийг бусдад түгээж, сурган хүмүүжүүлэх үүргээ сайн биелүүлэх гэдэг нь энэ асуулгаас харагдаж байна. Гэвч дургүй хүн гэсэн хариулт байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай болов уу.

Хүснэгт 2

Багшийн үндсэн үүрэг

Сургууль	Сурган хүмүүжүүлэгч	Мэдлэг өгөгч	Найз нөхөр	Дургүй хүн	Догнын хүн
МУИС	36.4	57.5	4.5	1.6	-
ХААИС	54.5	39.5	3.0	3.0	-
ШУТИС	42.2	42.2	-	11.0	4.6
ОУУБИС	43.0	56.0	1.0	-	-
Дундаж	44.0	48.8	2.8	5.2	

Багш оюутны харилцаанд ямар үнэлгээ өгөх талаар асуухад судалгаанд оролцогчид багш-оюутны харилцааг талаас илүү хувь нь (дундаж 56%) дунд зэрэг хэмээн үнэлжээ. Харин ХААИС, ШУТИС, ОУУБИС-ийн оюутнуудын 40 гаруй хувь нь энэ үзүүлэлтэд сайн үнэлгээ өгсөн байна. Эндээс үзэхэд багш-оюутны харилцаа шаардлагын хэмжээнд хүрээгүй байна гэж үзэж болох байх.

Хүснэгт 3

Багш оюутны харилцаа

Сургууль	Сайн	Дунд	Хангалтгүй
МУИС	26.5%	62.7%	10.8%
ХААИС	42.4%	57.6%	0%
ШУТИС	42.2%	55.6%	2.2%
ОУУБИС	47.0%	49.0%	4.0%
Дундаж	39.5%	56.2%	4.3%

Багш бүр оюутан нэг бүртэй ялгаварлалгүй харьцаж чадаж байна уу? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 33 хувь нь ихэнх багш нар оюутныг ялгаварлаж харилцдаг гэжээ. Харин 30 хувь нь багш нар ялгаварлан харилцах явдал хааяа гардаг гэсэн байна. Судалгаанаас үзвэл

ялгаварлан үзэх явдал ШУТИС (80%), ОУУБИС (64%), ХААИС (57.5%), МУИС (54%) байгаа / ихэнх нь болон хааяа/ гэжээ. Эндээс үзэхэд багш нарын дунд ялгаварлах явдал багагүй гардаг гэж оюутнууд үзэж байгааг анхаарвал зохих асуудал юм.

Хүснэгт 4

Багш нарын ялгаварлалын дүн

Сургууль	Тийм	Хааяа	Сайн мэдэхгүй байна	Үгүй
МУИС	21.2	32.9	28.8	17.1
ХААИС	33.3	24.2	36.4	6.1
ШУТИС	42.2	37.8	6.7	13.3
ОУУБИС	36.0	28.0	27.0	9.0
Дундаж	33.1	30.7	24.7	11.3

Багш оюутантай ялгаварлан харилцах гэдгийг оюутнууд янз бүрээр ойлгодог байна. Тухайлбал оюутны гадаад төрх (оюутнуудын 20%), сурлагын дүн болон оюутны харилцах чадвартай (тус бүр 30 гаруй хувь) холбоотойгоор багш нар ялгаварлан харилцаж байна гэж үзжээ. Энэ үзүүлэлтээс харахад зарим багш нар оюутантай тэгш харилцдаггүй явдал гардаг, гэхдээ энэ нь оюутан өөрийгөө зөв ойлгуулж, чөлөөтэй харилцаж чадахгүй байгаатай холбоотой хэмээн гэж 35 хувь нь үздэг ажээ. Эндээс үзвэл зарим оюутны өөрийгөө сайтар илэрхийлэх чадвар сулаас мэдлэг чадвараа дутуу үнэлүүлэх явдал гардаг, үүнийг ялгаварлан харилцаж байна гэж оюутан ойлгох тал ажиглагдсан. Иймд багшийн зүгээс ялангуяа бүрэг ноомой, дуу цөөтэй оюутантай тулж ажиллах, зөвлөх ажлыг түлхүү хийх шаардлагатай юм. Мөн энэ асуултад 14.8 хувь нь хариулаагүй хоосон үлдээсэн байгаа нь ялгаварлан үздэггүй гэж хариулсан хэсэг нь үлдээсэн байх магадлалтай.

Хүснэгт 5

Ялгаварлалд нөлөөлөх хүчин зүйлс

Сургууль	Гадаад төрх / хувцаслалт, бие бялдар гэх мэт/	Сурлагаар	Оюутны зан харилцаа (бүрэг ноомой)-тай холбоотой	Хариулаагүй
МУИС	22.3	28.9	41.0	7.8
ХААИС	12.1	39.4	42.4	6.1
ШУТИС	28.9	17.8	17.8	35.5
ОУУБИС	15.0	39.0	37.0	9.0
Дундаж	19.5	31.2	34.5	14.8

А. Багшийн хичээл заах ур чадвар, хичээлийн хэлбэр, бие даалтын ажил зэргийн талаарх

оюутнуудын дүгнэлт

Багшийн заах ур чадварыг оролцогчдын тал илүү хувь нь сайн, 40 гаруй хувь нь дунд зэрэг гэсэн бөгөөд хангалтгүй гэж үзсэн хувь нэлээд бага байв. ОУУБИС-ийн оюутнуудын 62 хувь нь багш нарын ур чадварыг “сайн”, ШУТИС-ийн тал илүү хувь нь “дунд зэрэг” гэжээ. Сургалтын төлбөр төлж сурдаг оюутнуудад багшийн хичээл ойлгомжтой байх нь нэн чухал төдийгүй цаашид сайн мэргэжилтэн бэлтгэхэд нөлөөтэй учир багш нарын заах ур чадварыг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Оюутнуудын 60 шахам хувь нь хичээлийг шинэлэг хэлбэрээр (лекц, семинарын хичээл дээр хичээлтэй холбоотой бичлэг үзүүлэх, статистикийн тоо баримт, шинэ мэдээлэл хэрэглэх гэх мэт) заалгах дуртай байдаг ажээ. Судалгаанд оролцогчдын 25 хувь нь өдөр бүр өөр хэлбэрээр заалгах сонирхолтой бөгөөд ХААИС-ийн оюутнууд бүгд шинэлэг хэлбэрээр болон өдөр бүр сонирхолтой байдлаар хичээлээ заалгахад дуртай гэжээ. Энэ хичээлийг нэг маягаар заах нь оюутнуудыг залхаах талтай байдгийг харуулж байна.

Оюутнуудын 60 шахам хувь нь бие даалтын ажлыг хичээлийн сэдвээр судалгаа хийж, тайлан боловсруулж хамгаалахыг ач холбогдолтой гэж үзжээ. Сургуулиудаар үзвэл ШУТИС-ийн оюутнуудын 40 гаруй хувь, МУИС-ийн оюутнуудын 35 хувь нь бизнесийн байгууллага дээр судалгаа хийж, тайлан хамгаалах нь ач холбогдолтой гэж үзсэн байна. Ер нь нийт оролцогчдын 90 шахам хувь нь компанийн үйл ажиллагаа гэх мэт бодит жишээн дээр судалгаа хийх нь чухал ач холбогдолтой гэж үздэг нь харагдсан.

В. Багш-оюутны харилцаанд тохиолдож буй сөрөг талууд

Багш шалгалтаа авч дүн гаргасны дараа оюутнууд тухайн багштай мэндлэхээ болих явдал гардгийг зарим багш нар дурдан ярилцсан. Тэгвэл судалгаанд оролцогчид багш-оюутны харилцаа таарамжгүй байсантай холбоотой (35%) болон оюутан хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд мэндлэхээ больдог (20%) гэжээ. Нийт сургуулийн дунджаар үзвэл 10.5 хувь нь багштай тааралдсан ч анзаарахгүй өнгөрдөг учир мэндэлдэггүй гэсэн байна. Харин багштай мэндлэхгүй байгаа нь зохимжгүй бөгөөд үүнд оюутны төлөвшил тааруу байгаатай холбоотой гэж 30 гаруй хувь нь үзсэн байна. Эндээс үзэхэд ямар ч тохиолдолд аливаа хүнтэй, тэр дотроо хичээл заасан багштай

мэндлэхгүй байх нь оюутны төлөвшил, ёс суртахуунтай холбоотой бөгөөд хүүхдийг бага насанд нь мэндлэх, хүндлэх ёсонд сургах нь чухал юм.

Оюутнуудын 56 хувь нь өөрт тохиолдсон бэрхшээлийн талаар багштайгаа ярилцахыг хүсдэггүй, 44 хувь нь хүсэж байдаг гэжээ. ШУТИС, ОУУБИС-ийн хувьд энэ үзүүлэлт 50 хувьтай байгаа нь багш нар оюутантай илүү харилцаа сайтай гэж үзэхэд хүргэж байна. Багш хичээл заахаас гадна оюутантай ойр дотно байж, суралцахад тулгарч буй аливаа бэрхшээлийг нь сонсдог, нааштай хандаж тусалдаг байх нь оюутны асуудлыг нааштай шийдвэрлэх, сургууль, багшид талархах сэтгэгдэлтэй үлдэх, оюутны цаашдын хандлага төлөвшилд нь үлгэр дуурайл болох зэрэг ач холбогдолтой.

Багшид өөрт учирсан бэрхшээлээ ярихгүй байгаа шалтгааныг авч үзвэл яриад ч нэмэргүй гэж бараг 40 хувь нь үздэг байна. Ярихыг хүссэн ч багшаас эмээдэг хэмээн 34 хувь нь үзсэн байхад итгэл даахуйц багш олдохгүй байсан гэж 27 хувь нь хариулсан. Эдгээр хариултаас үзэхэд оюутны багшид итгэх итгэл хангалттай бус, дүн гаргадаг багшаас айж эмээдэг, ярилцсан ч өөрийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй гэж боддог явдал нэлээд гардаг ажээ. Энэ нь багш нар хичээл заахаас гадна оюутныг ойлгож харилцах, тулгарсан асуудлыг нь нааштай авч үзэх явдал төдийлөн сайн бус байна гэж үзэж байна.

С.Оюутнуудын багш-оюутны харилцааны талаарх хүсэлт

Оюутнуудын 50 гаруй хувь нь багшийг хичээлээ ойлгомжтой заадаг (МУИС-аас бусад) байхыг хүсжээ. МУИС-ийн оюутнуудын 30 хувь нь ингэж үзсэн нь багш нарын заах чадвар бусад сургуулиас харьцангуй илүү байгаатай холбоотой гэж үзэж болох юм. Харин оюутныг ойлгодог, хүндэтгэлтэй, дотно харилцдаг байхыг нийт оюутны 56 хувь хүсжээ. Шударга ялгаваргүй ханддаг байхыг 10 гаруй хувь нь хүссэн. Харин 7 хувь нь шударга дүгнэдэг байхыг хүссэн бөгөөд багш нар үндсэндээ харьцангуй шударга дүгнэдэг хэмээн 90 гаруй хувь нь үзсэн нь сайшаалтай.

Багш-оюутны харилцааг сайжруулахын тулд оюутантай хүндэтгэлтэй, дотно харилцдаг байх нь зүйтэй хэмээн 34 хувь нь үзжээ. Хичээлийг ойлгомжтой заах, ялгаваргүй харилцах нь энэ харилцааг сайжруулах нэгэн арга зам хэмээн тус бүр 20 гаруй хувь нь үзсэн байна. Харин оюутны хүүхэд насны төлөвшил багш-оюутны харилцаанд нөлөөлж байгаа бөгөөд үүнд эцэг, эх, багш нар

анхаарах нь зүйтэй хэмээн 14 хувь нь үзсэн байна.

Багш-оюутны харилцааг сайжруулах нь чухал гэж нийт оюутан үзсэн бөгөөд үүний тулд хүндэтгэлтэй, ялгаваргүй харилцаж, хичээлээ сайн заахыг мөн чухалчилжээ. Багш-шавийн харилцаанд оюутны үүрэг оюутны үүрэг чухал гэдгийг оюутнууд ойлгож, хүүхэд ахуй үеийн хүмүүжил төлөвшил нөлөөлж байна гэж үзсэн байна.

“ШУТИС-ийн КТМС-ийн профессор, доктор Л.Оюунцэцэг, багш М.Заяа нарын 2007 онд хийсэн сургалтын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн судалгааны үр дүнгээс” манай судалгаатай холбогдох үзүүлэлтийг түүвэрлэн авч үзэхэд дараах байдалтай байв (Оюунцэцэг, Заяа, 2007, х4).

Хүснэгт 6

Сургалтын чанарт нөлөөлөх хүчин зүйлс

№	Багштай холбоотой үзүүлэлтүүд	Нэгдсэн үнэлгээ (5.0)
1	Багш нарын ур чадвар, заах арга зүй	3.96
2	Багш оюутны хоорондын харилцаа	3.56
3	Багш оюутны хамтын ажиллагаа	3.42
4	Оюутанд хандах хандлага хүндэтгэл	3.34
5	Оюутны дотнын зөвлөгч байх чадвар	3.17

Эх сурвалж: Л.Оюунцэцэг, М.Заяа. Дээд боловсролын байгууллагад чанарын удирдлагын тогтолцооны ISO9001 стандартыг нэвтрүүлэх боломж. СХЗҮТ, ШУТИС, КТМС. “ISO 9000-20 жилд” сэдэвт үндэсний чанарын бага хурлын илтгэлүүд. УБ, 2007

Дээрх үзүүлэлтээс харахад багш-оюутны харилцаа, оюутанд хандах хандлага хүндэтгэл; хамтын ажиллагаа, дотнын зөвлөгч байх чадвар зэрэг үзүүлэлтүүд (судлаачид 5 хүртэлх оноогоор үнэлсэн) төдийлөн өндөр бус байна.

Эндээс үзвэл багш-оюутны харилцааны түвшин арван жилийн өмнөхөөс төдийлөн өөрчлөгдөөгүй хэвээрээ шахам байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт, санал

1. Өнөөгийн багш-оюутны харилцааг оюутнуудын 40 хувь нь сайн, 56 хувь нь дунд зэрэг хэмээн үнэлж байгаагаас үзвэл багшийн зүгээс оюутантай харилцах ажиллагаанд дутагдалтай тал багагүй байна. Багш-оюутны харилцаанаас шалтгаалж оюутнууд өөрт тулгарсан бэрхшээлийг тэр бүр ярьдаггүй бөгөөд учир нь багшаас эмээдэг, ярьж чадсан ч сайн үр дүн гарахгүй гэж боддог ажээ.

2. Багш нар оюутныг ялгаварлан харилцах явдал гардаг гэж оюутнууд үздэг байна. Гадаад төрхөөр ялгаварлаж байна гэж (20%) үзсэн, харин

оюутан өөрийгөө багшид зөв ойлгуулж, чөлөөтэй харилцаж чадахгүй байгаагаас багш өөрөөр харилцдаг хэмээн гэж (35%) үзжээ. Мөн сурлага сайтай оюутанд багш илүү сайн хандах явдал байдаг (31%) гэжээ. Эндээс үзвэл зарим оюутны өөрийгөө сайтар илэрхийлэх чадвар сулаас мэдлэг чадвараа дутуу үнэлүүлдэг, үүнийг ялгаварлан харилцаж байна гэж ойлгодог байна. Иймд багшийн зүгээс сурлага сайнгүй болон бүрэг ноомой, дуу цөөтэй оюутантай тулж ажиллах, зөвлөх талаар түлхүү анхаарах нь зүйтэй.

3. Оюутнууд багшийг хичээлээ шинэлэг хэлбэрээр сонирхолтой заах; өөрсдийг нь ойлгож, хүндэтгэлтэй дотно хандах, шударга дүгнэх, ялгаваргүй харилцахыг хүсэж байгаа нь багш өөрийгөө хөгжүүлэх талаар улам илүү анхаарах хэрэгтэйг харуулж байна.

4. Оюутан шалгалт дууссаны дараа багштай мэндлэхээ болих явдал заримдаа тохиолддог бөгөөд энэ нь багш-оюутны харилцаатай зарим талаар холбоотой байдаг ажээ. Гэхдээ ямар ч тохиолдолд аливаа хүнтэй, тэр дотроо хичээл заасан багштай мэндлэхгүй байх нь тухайн оюутны төлөвшил, ёс суртахуунтай холбоотой бөгөөд хүүхдийг бага насанд нь мэндлэх, хүндлэх ёсонд сургаж дадал болгох нь зүйтэй.

5. Багш-оюутны харилцаанд одоогоос 10 жилийн өмнөх (судлаач Л.Оюунцэцэг, М.Заяа нарын судалгаа, 2007 он) үеэс хойш мэдэгдэхүйц ахиц дэвшил төдийлөн гараагүйд дүгнэлт хийж цаашид их, дээд сургуулийн багш нар анхаарах хэрэгтэй юм.

Багш-оюутны харилцааны талаар хийсэн судалгаанаас нэгтгэн дүгнэхэд багш нарын харилцаа, оюутанд хандах хандлага, сурган хүмүүжүүлэх арга барилыг сайжруулах өөрчлөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ашигласан материал

Оюунцэцэг, Л., Заяа, М. (2007). Дээд боловсролын байгууллагад чанарын удирдлагын тогтолцооны ISO9001 стандартыг нэвтрүүлэх боломж. СХЗҮТ, ШУТИС, КТМС. “ISO 9000-20 жилд” сэдэвт үндэсний чанарын бага хурлын илтгэлүүд.

Дүнчээ, С. (2008). Багшийн ёс суртахуун. “ДАНИДА NEWS” сэтгүүл. № 02 (13), х5

Study on the relations in university lecturers and student

J.Tungalag, Ts.Gantsetseg
NUM, Business School

Abstract

In this study, we aim to identify the current situation of teacher-student relations and the problems encountered. Studies have shown that students have their own conclusions on matters affecting the quality of teaching, such as communication between teacher-student, teacher's teaching skills, and the importance of self-reliance. Modern students living in electronic environments have improved their ability to live and evaluate in a number of different situations from previous generations, but they have lost a significant cultural tradition of respecting teachers and shown attitudes by discriminating teachers due to their family and social influences by dealing with something by money. It is a matter of continuing improvement of some of the teachers' own development and continuing improvement of knowledge and expertise in the student development as time requires.

The survey was based on a survey questionnaire survey questionnaire and was developed by SPSS 20 by econometric method. 40 percent of current students and 56 percent of students are moderate, and teachers do not have much to do with their students. Depending on the teacher-student relationship, students do not even talk about the difficulties they face because they think that the teacher is worried or talked about the good results. To summarize the study of teacher-student relations, it is necessary to change the relationship between teacher, attitude toward students and the teaching methodology.

Keywords

Education, educator, evaluation, NUM, MUST, IUU